



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 48

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 1,507,758,084 /нэг тэрбум таван зуун долоон сая долоон зуун тавин найман мянга наян дөрөв/ төгрөгийн өртөг бүхий Онги голын төмөр бетон гүүр /54.8 у/м/-ыг Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
48 дугаар тогтоолын хавсралт

Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал		Нэгжийн үнэ	Бүртгэх дүн
		Хэмжих нэгж	Биет хэмжээ		
1	Онги голын төмөр бетон гүүр	у/м	54.8	1,507,758,084	1,507,758,084
Дүн					1,507,758,084 /нэг тэрбум таван зуун долоон сая долоон зуун тавин найман мянга наян дөрөв/ төгрөг